

# МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ



## Захирлын мэндчилгээ

Эрдэм боловсролыг эрхэмлэгч Таныг Монгол улсын ууган их сургуульд элсч шилдэг эрдэмтэн багш нарын удирдлага дор, авьяас билиг дүүрэн үе тэнгийнхэнтэйгээ хамтдаа хүн төрөлхтний бүтээсэн мэдлэгийн охь шимээс суралцаж, чанартай боловсрол эзэмшихийг урьж байна. Манай сургуулийн шинэ хөтөлбөр таныг авьяас чадвараа нээн хөгжүүлж, сонирхсон чиглэлээрээ сонголт хийж хавсарга болон давхар мэргэшин суралцах өргөн боломж олгоно. Суралцах хугацаандаа газар газраас шилэгдэн ирсэн залуустай ажил мэргэжлийн насан туршийн холбоо тогтоох нандин боломж ч манайд байна.

Таны эрдмийн их үйлсэд амжилт хүсье!

## МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

-  Шинжлэх ухааны сургууль
  - Байгалийн ухааны салбар
  - Нийгмийн ухааны салбар
  - Хүмүүнлэгийн ухааны салбар
-  Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль
-  Бизнесийн сургууль
-  Хууль зүйн сургууль
-  Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль
-  Орхон сургууль
-  Завхан сургууль

## ЭЛСЭГЧ ТА

- Бүртгүүлэгч МУИС-ийн элсэлтийн системд Боловсролын үнэлгээний төвийн (БҮТ) системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээрээ нэвтэрч зааврын дагуу холбогдох талбаруудад мэдээллээ оруулж бүрэлдэхүүн сургууль/салбараа сонгон бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж элсэх хүсэлтээ гаргана.
- Боловсролын үнэлгээний төвөөс (БҮТ) ЭЕШ-ын дүнг албан ёсоор зарласан даруйд МУИС-ийн элсэлтийн систем бүртгүүлэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг татан авч, холбогдох тооцооллыг хийж, онооны жагсаалтыг бүрэлдэхүүн сургуулиар харуулна.
- Хяналтын тоонд багтсан элсэгч тодорхой нэг хөтөлбөр сонгож элсэхгүй, бүрэлдэхүүн сургууль/салбарт элсэнэ.

“

- Бүрэлдэхүүн сургууль/салбарт элсэж ороод МУИС-ийн Ерөнхий суурь хичээл судлах бөгөөд тухайн хичээлүүдээс өөрийн сонирхол, чадвар, цаашид мэргэшин сурах төлөвлөгөөний дагуу чөлөөтэй сонгон судлана.
- МУИС-ийн Ерөнхий суурь хичээлийг судалсан сурлагын голч, амжилттай судалсан хичээлийн багц цаг, ЭЕШ-ын оноогоор жагсаж үндсэн мэргэжлээ сонгоно.

”

- ШУС, ХШУИС-д элссэн оюутан тухайн сургуулиудын бүх хөтөлбөрөөс сонгон суралцах боломжтой. Мөн гүнзгийрүүлсэн сургалтат хөтөлбөрт (honors program) хамрагдах боломжтой.
- Оюутан бүрэлдэхүүн сургуулийн үндсэн мэргэжил олгох бүх хөтөлбөрөөс нэгийг сонгон суралцахын зэрэгцээ хавсарга, хос мэргэжил олгох хөтөлбөрөөр давхар суралцах боломжтой

## Монгол Улсын Их Сургуулийн Бакалаврын Өдрийн Хөтөлбөрт 2016 онд оюутан элсүүлэх журам

### 1-Р АЛХАМ

Бүртгүүлэгч МУИС-ийн элсэлтийн системд Боловсролын үнэлгээний төвийн (БҮТ) системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээрээ нэвтэрч зааврын дагуу холбогдох талбаруудад мэдээллээ оруулж бүрэлдэхүүн сургууль/салбараа сонгон бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж элсэх хүсэлтээ гаргана.



Элсэлтийн бүртгэл 2016 оны 04-р сарын 25-наас орон даяар онлайн-аар /цахим/ эхлэнэ. Элсэгч та <http://burtgel.num.edu.mn> хаягаар орж элсэхийг хүссэн МУИС-ийн бүрэлдэхүүн сургууль/салбараа сонгож бүртгүүлнэ.

1

### ЭЛСЭГЧДИЙН АНХААРАЛД

Элсэлтийн бүртгэл орон даяар **он-лайнаар** явагдахыг анхаарна уу!



Боловсролын үнэлгээний төвөөс (БҮТ) ЭЕШ-ын дүнг албан ёсоор зарласан даруйд МУИС-ийн элсэлтийн систем бүртгүүлэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг татан авч, холбогдох тооцооллыг хийж, онооны жагсаалтыг бүрэлдэхүүн сургуулиар харуулна.

2

### 2-Р АЛХАМ

Бүртгүүлсэн сургууль/салбарын хяналтын тоонд багтсан тохиолдолд элсэлтийн системээс бүртгүүлэгчид мэдэгдэнэ.



Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч 24 цагийн дотор элсэлтийн системд нэвтэрч хичээлийн жилийн эхний улирлын суурь үйлчилгээний төлбөрийг цахимаар төлж баталгаажуулна. Хяналтын тоонд багтсан элсэгч тодорхой нэг хөтөлбөр сонгож элсэхгүй, бүрэлдэхүүн сургууль/салбарт элсэнэ.

### 3-Р АЛХАМ

Элсэх эрх авсан сургууль/салбартаа бүртгүүлэхээр ирэхдээ бичиг баримтаа шалгуулж хураалгана

3

Элсэлтийн журам, бүрэлдэхүүн сургуулийн үндсэн хөтөлбөрийн талаархи мэдээллийг <http://burtgel.num.edu.mn>, <http://www.num.edu.mn> хаягаар орж дэлгэрэнгүй үзнэ үү.  
Холбоо барих утас: 77307730 (1121), (1122), (1123), (1125), (1126), (1127), (1129)

**МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ  
 2016 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРАМ**

**НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ<sup>1</sup>**

- 1.1. Монгол Улсын Их Сургууль (МУИС)-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт 2016 онд оюутан элсүүлэхэд Боловсрол Шинжлэх Ухааны сайдын 2013 оны 3 дугаар сарын 18-ны А/79 тоот тушаалаар батлагдсан “Оюутан элсүүлэх журам”, бусад холбогдох эрх зүйн акт болон энэхүү журмыг баримтална. 3.4
- 1.2. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, элсэлтийн хяналтын тоонд багтан элсэх эрх авсан бүртгүүлэгчийг “элсэгч”, элсэлтийн цахим бүртгэлийн системийг “элсэлтийн систем”, элсэлтийн үйл ажиллагааг зохион байгуулахаар томилогдсон ажлын хэсгийг “элсэлтийн комисс” гэнэ. 3.5
- 1.3. МУИС-ийн бакалаврын өдрийн хөтөлбөрт Улаанбаатар хот болон орон нутгаас элсүүлэх оюутны хяналтын тоог Боловсрол соёл шинжлэх ухааны яам (БСШУЯ) тогтооно. Элсэлтийн журам, бүрэлдэхүүн сургуульд элсүүлэхэд элсэлтийн ерөнхий шалгалт (ЭЕШ)-ын оноог тооцох болон холбогдох бусад мэдээллийг <http://burtgel.num.edu.mn>, [www.num.edu.mn](http://www.num.edu.mn) цахим хуудсанд байршуулна. МУИС-д гадаадын харьяат иргэдийг элсүүлэх асуудлыг “МУИС-д гадаадын иргэнийг элсүүлэн суралцуулах журам”-аар зохицуулна. 3.6

ухаан, Нийгмийн ухаан, Хүмүүнлэгийн ухааны салбараас сонгож бүртгүүлнэ. Бүртгүүлэгч нь өөрийн хүсэлтээр хэд хэдэн бүрэлдэхүүн сургуульд зэрэг бүртгүүлж болно. Бүртгүүлэгч нь Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-ийн хүчинтэй батламжтай, эсвэл 2016 онд ЭЕШ өгөхөөр БҮТ-д бүртгүүлсэн байна. Бүртгүүлэгч БҮТ-ийн систем дэх хувийн мэдээлэл, цахим шуудангийн хаяг, утасны дугаараа нягталж, алдаа мадаггүй болгосон байх шаардлагатай. Элсэлтийн системд бүртгүүлэгчийн оруулсан алдаатай мэдээллээс хамааран элсэлттэй холбоотой мэдээллийг авч чадаагүй бол МУИС хариуцахгүй. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн Монгол улсын иргэн МУИС-д элсэх хүсэлт гаргахдаа элсэхийг хүсч буй бүрэлдэхүүн сургуулийн элсэгчдийн онооны жагсаалтанд харгалзах “суурь” болон “дагалдах” ЭЕШ-тай дүйцүүлж болох шалгалтыг гадаад оронд өгсөн тухай тодорхойлолт, баримтыг хавсаргасан байна. Гадаад оронд ерөнхий боловсрол эзэмшсэн иргэдийн өргөдлийг цахимаар хүлээн авч салбар комиссын саналыг үндэслэн төв комисс шийдвэрлэнэ.

**ХОЁР. ЭЛСЭЛТИЙН КОМИСС**

- 2.1 МУИС-ийн элсэлтийн төв комиссын дарга нь сургалт эрхэлсэн дэд захирал, нарийн бичгийн дарга нь сургалтын нэгдсэн алба (СНА)-ны дарга, гишүүд нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, мэдээллийн технологийн албаны дарга, санхүү эдийн засгийн албаны дарга, салбар комиссын дарга нь бүрэлдэхүүн сургуулийн захирал, нарийн бичгийн дарга нь сургалтын албаны эрхлэгч, гишүүд нь дэд захирлууд байна.
- 2.1 Комисс нь элсэлтийн ажлыг зохион байгуулах, үүнтэй холбоотой зохицуулалт хийх чиг үүргийг хариуцан гүйцэтгэнэ.

**ДӨРӨВ. ЭЛСЭХ ХҮСЭЛТ ГАРГАХ**

- 4.1 МУИС-д элсэхийг хүссэн иргэд орон даяар, цахим хэлбэрээр <http://burtgel.num.edu.mn> хаягаар бүртгүүлнэ. Бүртгэлийг 2016 оны 4 дүгээр сарын 25-ны 09:00 цагт нээж 6 дугаар сарын 30-ны 18:00 цагт хаана.
- 4.2 Бүртгүүлэгч МУИС-ийн элсэлтийн системд БҮТ-ийн системд бүртгүүлсэн бүртгэлийн дугаар, нууц үгээрээ нэвтэрч зааврын дагуу холбогдох талбаруудад мэдээллээ оруулж элсэх хүсэлтээ гаргана.
- 4.3 Бүртгүүлэгч хувийн мэдээллээ шалгаж баталгаажуулсны дараа сонирхсон бүрэлдэхүүн сургууль/салбараа сонгон элсэлтийн бүртгэлийн хураамжийг цахим хэлбэрээр төлж баталгаажуулна (цахим картаар төлбөр хийх тухай дэлгэрэнгүй зөвлөмжийг элсэлтийн бүртгэлийн системээс үзэх боломжтой).
- 4.4 Элсэлтийн бүртгэлийн хураамж 15000 төгрөг байна. Энэ хураамжийг төлсөн бүртгүүлэгчийн сонгох сургууль/салбарын тоонд хязгаар тогтоохгүй. Бүртгэлийн хураамжийг буцаан олгохгүй.

**ГУРАВ. БҮРТГҮҮЛЭГЧДЭД ТАВИХ ШААРДЛАГА**

- 3.1 МУИС-д элсэхийг хүссэн иргэд энэхүү журамтай танилцаж элсэлтийн цахим бүртгэлд бүртгүүлнэ.
- 3.2 Бүртгүүлэгч нь БСШУЯ-ны Боловсролын үнэлгээний төв (БҮТ)-өөс зохион байгуулдаг ЭЕШ өгсөн хот, орон нутагтаа (харьяалал харгалзахгүй) өрсөлдөх эрхтэй.
- 3.3 Бүртгүүлэгч нь МУИС-ийн Шинжлэх ухааны сургууль, Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль, Бизнесийн сургууль, Хууль зүйн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль, Орхон сургууль, Завхан сургуулиас сонгож бүртгүүлнэ. Шинжлэх ухааны сургуулийн хувьд Байгалийн

**ТАВ. ЭЛСЭГЧИЙГ ШАЛГАРУУЛАХ БА МЭДЭГДЭХ**

- 5.1 БСШУЯ-аас тогтоосон улсын болон олон улсын олимпиадад оролцсон, БСШУЯ-аас тавих ЭЕШ-ын босго оноог хангасан Ерөнхий боловсролын сургууль (ЕБС) төгсөгчийг тухайн чиглэлээр БСШУЯ-ны тодорхойлолт болон холбогдох баримт бичигт үндэслэн шууд элсүүлнэ. Бизнесийн сургууль, Хууль зүйн сургууль, Олон улсын харилцаа, нийтийн

<sup>1</sup>Бакалаврын зэрэгтэй иргэн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт элсэх бол “МУИС-ийн бакалаврын орой, эчнээ хөтөлбөрт оюутан элсүүлэх журам”-аар, өдрийн хөтөлбөрт элсэн суралцах хүсэлтэй бол энэхүү журмаар зохицуулагдана.

- удирдлагын сургуулийн суурь шалгалтад заасан хичээлүүдээр улсын олимпиадад I-ҮI байр эзэлсэн бүртгүүлэгчийг шууд элсүүлнэ. Энэ нөхцөлийг хангасан бүртгүүлэгч “олимпиад” гэсэн ангиллаар бүртгүүлж, журмын 4.4-д заасан бүртгэлийн хураамж төлнө.
- 5.2 БҮТ-өөс ЭЕШ-ын дүнг албан ёсоор зарласан даруйд МУИС-ийн элсэлтийн систем бүртгүүлэгчийн элсэлтийн ерөнхий шалгалтын дүнг татан авч, холбогдох тооцооллыг хийж, онооны жагсаалтыг бүрэлдэхүүн сургуулиар тодорхойлж харуулна.
- 5.3 Бүртгүүлэгчийн оноог дараах байдлаар тооцно. “Суурь” шалгалтанд тооцохоор заасан хичээлээс хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.6 (Бизнесийн сургуульд бол 0.8)-аар, “Дагалдах” шалгалтад тооцохоор заасан хичээлээс мөн хамгийн өндөр оноо авсан шалгалтын оноог 0.4 (Бизнесийн сургуульд бол 0.2)-өөр үржүүлж нэмнэ. Ийнхүү тооцох “Суурь” болон “Дагалдах” шалгалтын оноо нь тус бүр БСШУЯ-наас баталсан Их, дээд сургуульд элсэгчдийн хангасан байх босго онооноос багагүй байна. Суурь шалгалтад тооцуулсан хичээлийн оноог дагалдах шалгалтад тооцуулахгүй.
- 5.4 Өмнөх нийлбэр оноо тэнцсэн тохиолдолд ЭЕШ-ын гүйцэтгэлийн хувийг тооцон байр эзлүүлж, элсэх эрх олгох ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.
- 5.5 Хяналтын тоонд багтсан эсэхийг бүртгэл хаасны дараа тогтоосон хугацаанд элсэлтийн системээр бүртгүүлэгчид мэдэгдэнэ.

### ЗУРГАА. ЭЛСЭХ ЭРХ ОЛГОХ

- 6.1 Элсэх эрх олгох үйл ажиллагааг орон даяар цахим хэлбэрээр явуулна.
- 6.2 Журмын 5.1 дүгээр заалтаар бүртгүүлэгч нь олимпиадад оролцсоныг гэрчлэх бичиг баримтын эх хувь, тэдгээрийн хуулбарын хамт 2016 оны 06 дугаар сарын 20-ноос 30-ны хооронд ажлын цагаар Сургалтын нэгдсэн албанд авч ирнэ.
- 6.3 Элсэлтийн эрх олгох үйл ажиллагааг БҮТ-өөс ЭЕШ-ын оноог нийтэд зарласан өдрөөс эхлэн долоо хоногийн хугацаанд зохион байгуулна.
- 6.4 Хэд хэдэн сургууль/салбарын хяналтын тоонд багтсан элсэгч нь зөвхөн нэг сургууль/салбарыг сонгох ба энэ нөхцөлд бусад сургууль/салбарын хяналтын тооны жагсаалтаас нэр нь хасагдаж босго шугам нэгээр доошилно. Босго шугам доошилсны дүнд хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчид элсэх эрх үүсч байгааг элсэлтийн системээр мэдэгдэнэ.
- 6.5 Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч элсэлтийн системд нэвтэрч хичээлийн жилийн эхний улирлын суурь үйлчилгээний төлбөрийг цахимаар төлж баталгаажуулна. Элсэн суралцахаа баталгаажуулснаа цуцлах тохиолдолд суурь үйлчилгээний төлбөрийг буцаан олгохгүй.<sup>2</sup>

<sup>2</sup>Хуваарь буцааснаар тухайн хуваарийг авах боломжтой, жагсаалтын дараагийн бүртгүүлэгч хуваарь авч чадахгүйд хүрч, эрх ашиг нь хөндөгддөг тул хариуцлагатай сонголт хийх ёстой гэдэг үүднээс урьдчилж төлүүлдэг. Түүнчлэн МУИС нөхөн элсэлт зохион байгуулахад хүрвэл гарах зардлыг энэхүү суурь үйлчилгээний

- 6.6 Бүртгүүлэгч хяналтын тоонд багтаж элсэх эрхтэй болсоноос хойш 24 цагийн дотор элсэн суралцахаа баталгаажуулна. Хэрэв ингэж баталгаажуулаагүй тохиолдолд МУИС-д элсэхээс татгалзсан гэж үзэн жагсаалтын дараах бүртгүүлэгчийг босго шугамын дээр дэвшүүлэн элсэх эрх шилжинэ.
- 6.7 Элсэгч нь суралцахаа баталгаажуулсны дараа түүний цахим шуудангийн (e-mail) хаягаар МУИС-д суралцах журамтай холбогдох мэдээлэл, мэдээллийн системийг ашиглах заавар зэргийг илгээнэ.

### ДОЛОО. ЭЛСЭГЧИЙГ БҮРТГЭХ

- 7.1 Элсэгчид нь дараах бичиг баримтыг бүрдүүлэн 2016 оны 08 дугаар сарын 01-нээс 08 дугаар сарын 22-ны хооронд ажлын цагаар бүрэлдэхүүн сургуулийн сургалтын албанд өөрийн биеэр авчирч бүртгүүлнэ. Үүнд:
- Иргэний үнэмлэх эсвэл түүнтэй адилтгах баримт бичиг (төрсний гэрчилгээ, гадаад паспорт), хуулбарын (ар, өвөр тал нэг нүүрт) хамт;
  - МУИС-д элсэгчийн анкет (МУИС-ийн загварын дагуу);
  - Бүрэн дунд боловсролын гэрчилгээ (хэрэв түүнээс дээш шатны боловсрол эзэмшсэн бол гэрчлэх баримт бичиг, хуулбарын хамт);
  - ЭЕШ-ын батламж, хуулбарын хамт;
  - Цээж зураг 2 хувь, оюутны үнэмлэхийн шаардлагад нийцсэн цээж зураг файл хэлбэрээр (аль аль нь сүүлийн 3 сарын дотор авахуулсан байх) бүрдүүлэн эдгээр бичиг баримтыг битүүмжлэл сайтай хавтсанд хийсэн байна.

### НАЙМ. БУСАД

- 8.1 Нэг бүрэлдэхүүн сургуулиас нөгөө бүрэлдэхүүн сургууль/салбарт шилжүүлэн элсүүлэхгүй ба хуваарийг бусдад шилжүүлэхийг зөвшөөрөхгүй.
- 8.2 Элсэх эрхээ баталгаажуулсан боловч, бүрдүүлэх бичиг баримтаа 7.1-д заасан хугацаанд авчирч бүртгүүлээгүй бол МУИС-д суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийг хүчингүйд тооцно.
- 8.3 Элсэлттэй холбоотой бичиг баримтыг хуурамчаар үйлдсэн нь тогтоогдвол МУИС-д элсүүлэхгүй.
- 8.4 Цахим бүртгэл хийж байх үед МУИС-ийн бүрэлдэхүүн сургуулиуд зөвлөгөө өгөх үйл ажиллагааг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл, утас, мессенжер, цахим шуудан, вэб хуудас зэргийг ашиглан явуулна.

төлбөрөөс санхүүжүүлдэг болно.

**МУИС-ИЙН БАКАЛАВРЫН ӨДРИЙН ХӨТӨЛБӨРТ  
 2016 ОНД ОЮУТАН ЭЛСҮҮЛЭХ ЖУРМЫН ХҮСНЭГТ**

	МУИС-ийн БҮРЭЛДЭХҮҮН СУРГУУЛЬ	ЭЛСЭЛТИЙН ШАЛГАЛТ		СОНГОХ БОЛОМЖТОЙ БАКАЛАВРЫН ҮНДСЭН МЭРГЭЖЛИЙН ХӨТӨЛБӨР
		“Суурь” шалгалт (60%)	“Дагалдах” шалгалт (40%)	
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН БАЙГАЛИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> <li>Биологи</li> <li>Газарзүй</li> <li>Математик</li> <li>Физик</li> <li>Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Биологи</li> <li>Газарзүй</li> <li>Математик</li> <li>Монгол хэл</li> <li>Монголын түүх</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> <li>Физик</li> <li>Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Багш, байгалийн ухааны боловсрол</li> <li>Багш, математикийн боловсрол</li> <li>Байгаль орчныг зайнаас тандан судлал</li> <li>Биологи</li> <li>Биологийн нөөц судлал</li> <li>Биохими</li> <li>Биотехнологи</li> <li>Газарзүй</li> <li>Газар зохион байгуулалт</li> <li>Геологи</li> <li>Геофизик</li> <li>Математик</li> <li>Физик</li> <li>Хими</li> <li>Хот ба бүс нутгийн төлөвлөлт</li> <li>Экологи</li> </ul>
2	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> <li>Математик</li> <li>Монголын түүх</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Биологи</li> <li>Газарзүй</li> <li>Математик</li> <li>Монгол хэл</li> <li>Монголын түүх</li> <li>Орос хэл</li> <li>Физик</li> <li>Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Антропологи</li> <li>Археологи</li> <li>Нийгмийн ажил</li> <li>Социологи</li> <li>Сэтгүүл зүй</li> <li>Сэтгэл судлал</li> <li>Улс төр судлал</li> <li>Эдийн засаг</li> </ul>
3	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН ХҮМҮҮНЛЭГИЙН УХААНЫ САЛБАР	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Монгол хэл</li> <li>Монголын түүх</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> <li>Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Биологи</li> <li>Газарзүй</li> <li>Математик</li> <li>Монгол хэл</li> <li>Монголын түүх</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> <li>Орос хэл</li> <li>Физик</li> <li>Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Багш, гадаад хэлний боловсрол</li> <li>Багш, монгол хэл- уран зохиолын боловсрол</li> <li>Багш, нийгмийн ухааны боловсрол</li> <li>Гадаад хэлний орчуулга</li> <li>Олон улс, орон судлал</li> <li>Түүх</li> <li>Урлаг судлал</li> <li>Утга зохиол судлал</li> <li>Философи</li> <li>Хэл, уран зохиол /Монгол хэл, уран зохиол, Гадаад хэл, уран зохиол/</li> <li>Хэлшинжлэл /Монгол хэл шинжлэл, Гадаад хэл шинжлэл/</li> <li>Шашин судлал</li> </ul>
4	ХЭРЭГЛЭЭНИЙ ШИНЖЛЭХ УХААН, ИНЖЕНЕРЧЛЭЛИЙН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> <li>Биологи</li> <li>Математик</li> <li>Физик</li> <li>Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Биологи</li> <li>Газарзүй</li> <li>Математик</li> <li>Монгол хэл</li> <li>Физик</li> <li>Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Байгаль орчныг хамгаалах технологи</li> <li>Био-инженерчлэл</li> <li>Компьютерийн сүлжээ</li> <li>Компьютерийн ухаан</li> <li>Материал судлал</li> <li>Мэдээллийн систем</li> <li>Мэдээллийн технологи</li> <li>Нано шинжлэх ухаан, инженерчлэл</li> <li>Ойн үйлдвэрлэлийн техник, технологи</li> <li>Программ хангамж</li> <li>Статистик</li> <li>Сэргээгдэх эрчим хүч</li> <li>Ус судлал</li> <li>Химийн инженерчлэл</li> <li>Холбооны технологи</li> <li>Хүрээлэн буй орчин судлал</li> <li>Хэрэглээний математик</li> <li>Хэрэглээний хими</li> <li>Цаг уур</li> <li>Цөмийн инженерчлэл</li> <li>Электрон системийн автоматжуулалт</li> </ul>

5	БИЗНЕСИЙН СУРГУУЛЬ	“Суурь” шалгалт (80%)	“Дагалдах” шалгалт (20%)	<ul style="list-style-type: none"> <li>Аялал жуулчлалын менежемент</li> <li>Бизнесийн удирдлага</li> <li>Даатгал</li> <li>Зочлох үйлчилгээ</li> <li>Маркетинг</li> <li>Менежмент</li> <li>Худалдаа</li> <li>Нягтлан бодох бүртгэл</li> <li>Санхүү, банк</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>Математик<sup>80%</sup></li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл<sup>20%</sup></li> <li>Нийгмийн тухай мэдлэг<sup>20%</sup></li> <li>Орос хэл<sup>20%</sup></li> </ul>	
6	ХУУЛЬ ЗҮЙН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Математик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Эрхзүй</li> </ul>
7	ОЛОН УЛСЫН ХАРИЛЦАА, НИЙТИЙН УДИРДЛАГЫН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Математик</li> <li>Монгол хэл</li> <li>Монголын түүх</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> <li>Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Математик</li> <li>Монгол хэл</li> <li>Монголын түүх</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> <li>Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нийтийн удирдлага</li> <li>Олон улсын харилцаа</li> </ul>
8	ОРХОН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл</li> <li>Англи хэл</li> <li>Орос хэл</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Багш, гадаад хэлний боловсрол</li> <li>Гадаад хэлний орчуулга</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>Монгол хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Багш, монгол хэл-уран зохиолын боловсрол</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>Математик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Даатгал</li> <li>Маркетинг</li> <li>Менежмент</li> <li>Нягтлан бодох бүртгэл</li> <li>Санхүү, банк</li> </ul>
9	ЗАВХАН СУРГУУЛЬ	<ul style="list-style-type: none"> <li>Математик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Нийгмийн тухай мэдлэг</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Нягтлан бодох бүртгэл</li> <li>Санхүү, банк</li> <li>Маркетинг</li> <li>Менежмент</li> <li>Худалдаа</li> <li>Бичиг хэрэг, оффисийн ажилтан</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>Математик</li> <li>Физик</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Биологи</li> <li>Математик</li> <li>Физик</li> <li>Хими</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Электрон системийн автоматжуулалт</li> </ul>
		<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Англи хэл</li> <li>Математик</li> <li>Монгол хэл</li> <li>Орос хэл</li> </ul>	<ul style="list-style-type: none"> <li>Багш, гадаад хэлний боловсрол (англи)</li> </ul>

**Тайлбар:**


- МУИС-д элсэхийг хүссэн иргэн хүснэгтэнд заасан бүрэлдэхүүн сургууль/салбарт бүртгүүлэх бөгөөд ЭЕШ-ын шалгалтын оноогоороо элсэлтийн хяналтын тоонд багтсан тохиолдолд МУИС-ийн оюутан болж элсэх эрхтэй болно. Элсэгч нь тухайн бүрэлдэхүүн сургуулийн бакалаврын бүх хөтөлбөрөөс мэргэжлийн хөтөлбөр сонгуулах журамд зааснаар сонгон суралцах бололцоотой бөгөөд сурлагын дүн, анх элсэхээр бүртгүүлэхдээ тооцуулсан ЭЕШ-ын оноо өндөр байх тусам мэргэжил сонгохдоо давуу эрх эдэлнэ. ШУС, ХШУИС-д элссэн оюутан тухайн сургуулиудын бүх хөтөлбөрөөс сонгон суралцах боломжтой. Түүнчлэн зарим хөтөлбөрийн хувьд бэлтгэж буй мэргэжил, шинжлэх ухааны онцлогоос үүдэн оюутанд тусгай шаардлага тавина.
- МУИС-д элссэн оюутан нь өөрийн сонгосон үндсэн мэргэжлээс гадна МУИС-ийн санал болгох “Хавсарга” мэргэжлээс сонгон судалж, “Үндсэн мэргэжил”, “Хавсарга мэргэжил” эзэмших боломжтой болно. Жишээлбэл, ШУС-д Физик мэргэжлээр суралцаж байгаа оюутан Бизнесийн сургуулийн Менежмент хөтөлбөрөөр хавсарга мэргэжил эзэмших боломжтой.
- ШУС болон ХШУИС-д элсэн орсон элсэгчид гүнзгийрүүлсэн сургалтат хөтөлбөрт (honors program) хамрагдах боломжтой ба тусгай журмаар зохицуулна. Энэхүү хөтөлбөр нь зөвхөн суурь боловсрол олгох бөгөөд бусад оюутны адил мэргэжлээ сонгон суралцана.

**МУИС-ИЙН 2016-2017 ОНЫ ЭЛСЭЛТИЙН СИСТЕМИЙН  
ГАРЫН АВЛАГА**

**1. Системд нэвтрэх, хувийн мэдээллээ хянах**




дугаараа оруулах, засах хэсэг байгаа бөгөөд элсэлттэй холбоотой руу очих болно.




МУИС-ийн элсэлтийн системд нэвтрэхдээ Үндсэн нүүр цэсний нэвтрэх хэсгээр БҮТ-ийн системд нэвтрэдэг бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтрэнэ. Бүртгүүлэгч нь БҮТ системд нэвтрэдэг бүртгэлийн дугаар, нууц үг мөн манай системийн нууцлалын кодыг том жижиг үсгийн ялгаатайгаар оруулж Нэвтрэх товч дээр дарна. Элсэлтийн системд амжилттай нэвтэрсэн тохиолдолд бүртгүүлэгчийн дараах үндсэн хуудас гарч ирэх болно. Энэ хуудасны зүүн хэсэгт бүртгүүлэгчийн хувийн мэдээлэл болон элсэлтийн шалгалтын дүнгийн мэдээлэл /ЭШ-ын дүн гарсан тохиолдолд/ харгандана. Хувийн мэдээллийн хэсэгт цахим шуудан болон утасны мэдээллүүд таны оруулсан цахим шуудан болон утас

Санамж: МУИС-ийн элсэлтийн систем рүү нэвтрэхгүй байгаа тохиолдолд БҮТ-ийн систем рүү нэвтэрч үзнэ. Хэрвээ БҮТ-ийн систем рүү нэвтрэхгүй байгаа тохиолдолд БҮТ-д хандана. Хэрвээ БҮТ-ийн систем рүү нэвтэрч байгаа боловч МУИС-ийн элсэлтийн систем рүү нэвтрэхгүй байгаа тохиолдолд МУИС-ийн Мэдээллийн Технологийн Алба / 77307730-1153,1151 Хичээлийн 2-р байр өргөтгөлийн 5 давхар 501 тоот / -тай холбоо барина уу. Бүртгүүлэгчийн хувийн мэдээлэл алдаатай байвал БҮТ-д хандана. Бүртгүүлэгчийн цахим шуудан, утасны дугаар өөрчлөгдсөн бол заавал шинэчилж хадгална.

**2. Бүртгүүлэх сургуулиа сонгох**



Бүртгүүлэгч хувийн мэдээллээ шалгаж баталгаажуулсны дараа бүрэлдэхүүн сургууль/салбарын жагсаалтаас сонирхсон бүрэлдэхүүн сургууль/салбараа сонгоно. Бүртгүүлэгчийн үндсэн хуудсанд байрлах БҮРТГҮҮЛЭХ товч дээр даргахад элсэлт авах сургуулиудын жагсаалт гарч ирэх бөгөөд бүртгүүлэгч сонирхсон хэдэн ч сургуульд давхар бүртгүүлэх боломжтой. Бүртгүүлэгч бүртгүүлэх сургуулиудаа сонгосны дараа Бүртгүүлэх >> товч дээр даран дараагийн алхамд шилжинэ.



Бүртгүүлэх сургуулиудаа сонгон Бүртгүүлэх >> товч дээр дарснаар бүртгүүлэгчээс улсын олимпиадад оролцсон эсэх талаар дараах асуултыг асууна. Хэрвээ бүртгүүлэгч улсын олимпиадад оролцож байсан бол Тийм оролцож байгаагүй бол Үгүй товчийг даран дараагийн алхамд шилжинэ. Дээрх асуултанд хариулсны дараа бүртгэлийн хураамжаа төлж бүртгэлээ баталгаажуулна.

**3. Бүртгэлийн хураамж төлөх**

Бүртгүүлэгч нь бүртгэлээ баталгаажуулж бүртгэлийн хураамжаа заавал төлөх ёстой ба бүртгэлийн хураамжийг дараах хэлбэрээр төлөх боломжтой. Үүнд:

- Онлайн буюу цахим хэлбэрээр
- PayBill үйлчилгээгээр

**Онлайн буюу цахим хэлбэрээр бүртгэлийн хураамж төлөх**



Бүртгэлийн хураамжийг онлайн буюу цахим хэлбэрээр төлөх бол Онлайнаар төлөх товч дээр дарх ба танд ХААН, ГОЛОМТ болон ТӨРИЙН банкны онлайн гүйлгээ хийх эрхтэй карт байх хэрэгтэй. Эдгээр банкны онлайн гүйлгээ хийх эрхтэй карттай бол та дараах банкны жагсаалтаас сонгоно. Хэрвээ та ХААН банкны карттай бол Хаан гэсэн товч дээр, ГОЛОМТ банкны карттай бол Голомт гэсэн товч дээр, ТӨРИЙН банкны карттай бол Төрийн банкаар гэсэн товч дээр дарна.

Аль банкаар хураамж төлөхөөс шалтгаалан тухайн банкны систем дуудагдах ба хураамжийг нэхэмжилсэн хуудас банкны системд очно. Та банкны системийн шаардлагатай мэдээллүүдийг бөглөн хураамжаа төлж бүртгэлээ баталгаажуулна.

**PayBill үйлчилгээгээр бүртгэлийн хураамж төлөх**

PayBill үйлчилгээ нь бүртгүүлэгч бүртгэлийн хураамжаа бэлнээр МУИС-ийн дансанд хийхийг хэлнэ.

№	Банкны нэр	Дансны дугаар
1	ХААН	5041355868
2	ГОЛОМТ	1102927741

Энэ үйлчилгээний давуу тал нь:

- Бүртгүүлэгч заавал карт ашиглах шаардлагагүй
- Бүртгүүлэгч аль ч банкаар үйлчлүүлэн төлбөрөө төлж болно
- Бүртгүүлэгч банк хоорондын гүйлгээ хийх боломжтой
- Бүртгүүлэгч өөрийн биеэр банкны теллерээр үйлчлүүлэхээс гадна төлбөр төлөх бусад хэлбэрүүдийг ашиглаж болно. Үүнд: интернет банк, смарт банк, mobile банк гэх мэт

Үйлчилгээнд тавигдах шаардлага:

- Бүртгүүлэгч МУИС-ийн ХААН болон ГОЛОМТ банкин дахь харилцах дансны дугаарыг мэддэг байх
- Аль ч төрлийн гүйлгээ хийхэд гүйлгээний утга/төлбөрийн зориулалт хэсэгт БҮТ-ийн системд нэвтэрдэг бүртгэлийн дугаар -аа заавал бичнэ. Бүртгэлийн дугаарын араас зай аваад дурын текст бичиж болно. Жишээ нь: [БҮТ-ийн бүртгэлийн дугаар] зай аваад [Регистрийн дугаар] [Овог Нэр]

PayBill үйлчилгээгээр бүртгэлийн хураамжаа төлөхдөө гүйлгээний утга/төлбөрийн зориулалт хэсэгт БҮТ-ийн системд нэвтэрдэг бүртгэлийн дугаар -аа зөв бичсэн тохиолдолд 10-20 минутын дотор таны төлсөн хураамж МУИС-ийн данс руу орж ирэх ба



бүртгүүлэгч **МУИС-ийн элсэлтийн систем рүү нэвтрэн орж бүртгүүлэх сургуулиа сонгон Бүртгүүлэх >> товч дээр заавал дарж бүртгэлээ заавал баталгаажуулна.** Бүртгүүлэх >> товч дээр дарснаар хэрвээ таны төлсөн бүртгэлийн хураамж МУИС-ийн дансанд амжилттай орж ирсэн бол бүртгэл шууд баталгаажна.


Харин Бүртгүүлэх >> товч дээр дарахад банкны сонголт гарч ирвэл бүртгүүлэгч гүйлгээний утга/төлбөрийн зориулалт хэсэгт БҮТ-ийн системд нэвтрэдэг бүртгэлийн дугаар -аа буруу бичсэн гэсэн үг. Энэ тохиолдолд МУИС-ийн Мэдээллийн Технологийн Алба / 77307730-1153,1151 Хичээлийн 2-р байр өргөтгөлийн 5 давхар 501 тоот / -тай заавал холбоо барих шаардлагатайг анхаарна уу.

Санамж:

- Хураамжийг онлайнар төлөх бол заавал онлайн гүйлгээ хийх эрхтэй картаар хийнэ. / E-code заавал авсан байна /
- Банкны карт нь заавал таны карт байх албагүй.
- Бүртгүүлэгч ямар банкны карттай байхаас хамааран тухайн банкны онлайн системээр хураамжаа төлнө. Жишээ нь: Хаан банкны карттай бол Хаан банкны төлбөрийн системээр хийнэ.
- Банкны системээр гүйлгээ хийхэд амжилттай, амжилтгүй хариу банкны системээс өгнө. Зөвхөн амжилттай хариу ирсэн тохиолдолд таны бүртгэл баталгаажна.
- Банкны системээс МУИС-ийн элсэлтийн системд амжилттай хариу илгээгээгүйн улмаас таны хураамж төлсөн картнаас мөнгө нь хасагдсан боловч бүртгэл нь баталгаажаагүй тохиолдолд МУИС-ийн Мэдээллийн Технологийн Алба / 77307730-1153,1151 Хичээлийн 2-р байр өргөтгөлийн 5 давхар 501 тоот / -тай холбоо барина уу.
- PayBill үйлчилгээгээр бүртгэлийн хураамжаа төлөх тохиолдолд гүйлгээний утга/төлбөрийн зориулалт хэсэгт БҮТ-ийн системд нэвтрэдэг бүртгэлийн дугаар -аа заавал бичнэ. Хэрвээ бүртгэлийн дугаараа буруу бичсэн тохиолдолд МУИС-ийн Мэдээллийн Технологийн Алба / 77307730-1153,1151 Хичээлийн 2-р байр өргөтгөлийн 5 давхар 501 тоот / -тай холбоо барина уу.
- Бүртгүүлсэн сургууль дээрээ нэмээд хураамж төлөхгүйгээр өөр сургуульд бүртгүүлэх боломжтой.

#### 4. Бүртгэл баталгаажсан эсэхийг шалгах

Бүртгүүлэгч бүртгэлийн хураамжаа амжилттай төлөн бүртгэл нь амжилттай баталгаажсан бол системийн үндсэн хуудсанд бүртгүүлсэн сургуулиудын жагсаалт гарч ирэх болно.



Санамж:

- Бүртгүүлэгч бүртгэл нь баталгаажсан эсэхийг заавал шалгана.
- Бүртгүүлэгч Онлайн болон PayBill үйлчилгээгээр төлбөрөө төлсөн боловч бүртгэл нь баталгаажаагүй бол МУИС-ийн Мэдээллийн Технологийн Алба / 77307730-1153,1151 Хичээлийн 2-р байр өргөтгөлийн 5 давхар 501 тоот / -тай холбоо барьж зөвлөгөө авна.
- Бүртгүүлсэн сургууль дээрээ нэмээд хураамж төлөхгүйгээр өөр сургуульд бүртгүүлэх боломжтой.

#### 5. Системд нэвтрэх, ЭЕШ-ын оноо харах

МУИС-ийн элсэлтийн системд нэвтрэхдээ Үндсэн нүүр цэсний нэвтрэх хэсгээр БҮТ-ийн системд нэвтрэдэг бүртгэлийн дугаар, нууц үгээ ашиглан нэвтрэнэ. Бүртгүүлэгч нь БҮТ системд нэвтрэдэг бүртгэлийн дугаар, нууц үг мөн манай системийн нууцлалын кодыг том жижиг үсгийн ялгаатайгаар оруулж Нэвтрэх товч дээр дарна.



Боловсролын үнэлгээний төв-өөс Элсэлтийн ерөнхий шалгалт-ын оноог зарласан тохиолдолд МУИС-ийн элсэлтийн системийн зүүн доод хэсэгт таны оноо байршина.

Дүнгийн мэдээлэл		
Хичээлийн нэр	Гүйцэтгэл	Дүйцүүлсэн оноо
Математик	36	603
Нийгмийн тухай мэдлэг	55	571
Англи хэл	44	611
Хими	22	497

ЭЕШ-ын оноо

Санамж:

- МУИС-ийн элсэлтийн систем рүү нэвтрэхгүй байгаа тохиолдолд БҮТ-ийн систем рүү нэвтрэх үзнэ. Хэрвээ БҮТ-ийн систем рүү нэвтрэхгүй байгаа тохиолдолд БҮТ-д хандана. Хэрвээ БҮТ-ийн систем рүү нэвтрэхгүй байгаа боловч МУИС-ийн элсэлтийн систем рүү нэвтрэхгүй байгаа тохиолдолд МУИС-ийн Мэдээллийн Технологийн Алба / 77307730-1153,1151 Хичээлийн 2-р байр өргөтгөлийн 5 давхар 501 тоот / -тай холбоо барина уу.
- Бүртгүүлэгчийн хувийн мэдээлэл алдаатай байвал БҮТ-д

хандана.

- Бүртгүүлэгчийн цахим шуудан, утасны дугаар өөрчлөгдсөн бол заавал шинэчилж хадгална.
- ЭЕШ-ын оноог БҮТ-өөс шууд татдаг болно.

**6. Элсэгчийг шалгаруулах ба мэдэгдэх**

БҮТ-өөс ЭЕШ-ын дүнг зарламагц бүртгүүлэгчийн бүртгүүлсэн сургууль/салбарын элсэлтийн шалгалтанд хамаарах хувилбаруудыг тооцоолон хамгийн өндөр оноотой ( Бүрэлдэхүүн сургууль/салбар тус бүр элсэлтийн “суурь” болон “дагалдах” гэсэн хоёр шалгалттай ба хоёр шалгалтын оноог журамд заасан харьцаагаар үржүүлж нэмнэ. ) хувилбараар бүрэлдэхүүн сургууль/салбарын жагсаалтанд байр эзлүүлнэ.

Сургууль/салбар тус бүрт харгалзах **Жагсаалт харах** товч дээр дарж тухайн сургууль/салбарт бүртгүүлсэн нийт бүртгүүлэгчдийн онооны жагсаалтыг харах, хянах боломжтой.

Бүртгүүлэгчийн эзэлсэн байр тухайн сургууль/салбарын хяналтын тоонд багтаж байвал МУИС-д элсэх эрхтэй болсон гэж үзэх бөгөөд элсэлтийн системд бүртгэлтэй байгаа утасны дугаар руу элсэх эрхээ баталгаажуулах талаар мессеж илгээнэ.

**Санамж:**

- Хяналтын тоонд багтсан эсэхийг бүртгэл хаагдсаны дараа тогтоосон хугацаанд бүртгүүлэгчид мэдэгдэнэ.
- Та хяналтын тоонд багтсан боловч таны утсанд тодорхой шалтгааны улмаас ( утасны дугаараа буруу оруулсан гэх мэт... ) мессеж очихгүй байх магадлалтай. Иймд та элсэлтийн систем рүү байнга хандан хянах шаардлагатай.
- Жагсаалтанд таны эзэлсэн байр доогуур байсан ч та хяналтын тоонд багтах магадлалтай юм. Учир нь нэг элсэгч хэд хэдэн сургууль/салбарт зэрэг бүртгүүлсэн ч зөвхөн нэг л сургууль/салбарт элсэх боломжтой тул таны өмнөх бүртгүүлэгч

- өөр сургууль/салбарыг сонговол таны эзэлсэн байр дээшилж та хяналтын тоонд багтах боломжтой болно.
- Жагсаалтын оноо тэнцсэн тохиолдолд гүйцэтгэлийн хувиар байр эзлүүлэх ба гүйцэтгэлийн хувь тэнцвэл боловсролын гэрчилгээний дундаж оноог харгалзана.

**7. Элсэх эрхээ баталгаажуулах, татгалзах, цуцлах**

Бүртгүүлэгч тухайн сургууль/салбарын хяналтын тоонд багтсан бол дараах зурагт үзүүлснээр өнгөөр ялгаран харагдана.

Бүртгүүлэгч тухайн сургууль/салбарын хяналтын тоонд багтсан бол дараах боломжуудтай. Үүнд:

- Элсэх эрхээсээ татгалзах
- Элсэх эрхээ баталгаажуулах
- Баталгаажуулсан эрхээ цуцлах

**Элсэх эрхээсээ татгалзах**


Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан сургууль/салбарын харгалзах **Татгалзах** товч дээр даран элсэх эрхээсээ татгалзах боломжтой. Элсэх эрхээсээ татгалзсан тохиолдолд тухайн салбар/сургуульд элсэх боломжгүй болно. **Татгалзах** товч дээр дарснаар дараах асуултыг бүртгүүлэгчээс лавлаж асуух бөгөөд хэрвээ татгалзахыг зөвшөөрч байвал харгалзах нүдийг сонгон гарч ирэх товч дээр даран элсэх эрхээсээ татгалзана.

#	Бүртгүүлсэн сургууль	Шалгалт (Оноо)	Үлдсэн Нийт хуваарийн тоо	Одоогоор эзэлсэн байр	Баталгаажуулах хугацаа	
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Англи хэл (605.4)	5 / 5	3	2015-07-01Т14:19:00	Жагсаалт харах Татгалзах





### Элсэх эрхээ баталгаажуулах

Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч элсэх эрх олгох үйл ажиллагаа эхэлснээс хойш журамд заасан хугацааны дотор элсэх эрхээ баталгаажуулна. Хэрвээ журамд заасан хугацааны дотор элсэх эрхээ баталгаажуулаагүй тохиолдолд элсэх эрхээсээ татгалзсан гэж үзэн шугамын доор байгаа бүртгүүлэгчид элсэх эрх шилжинэ. Энэ нөхцлөөр хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч элсэх эрхээ журамд заасан хугацааны дотор баталгаажуулах бөгөөд энэ хугацаанд элсэх эрхээ баталгаажуулаагүй бол мөн элсэх эрхээсээ татгалзсан гэж үзэж дараагийн бүртгүүлэгчид шилжинэ. Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийн элсэх эрхээ баталгаажуулах хугацаа системд байрлан бүртгүүлэгчид харгдана. Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан салбар/сургуульдаа элсэх эрхээ баталгаажуулах бол дараах зурагт үзүүлсэн харгалзах нүдийг сонгон **Баталгаажуулах** товч дээр дарна. **Баталгаажуулах** товч дээр дарснаар дараах асуултыг бүртгүүлэгчээс лавлаж асуух бөгөөд хэрвээ баталгаажуулахыг



зөвшөөрч байвал харгалзах нүдийг сонгон гарч ирэх **Үргэлжлүүлэх** товч дээр даран үргэлжлүүлнэ.

**Үргэлжлүүлэх** товч дээр дарсны дараа бүртгүүлэгч элсэх эрхээ баталгаажуулахын тулд эхний улирлын суурь үйлчилгээний төлбрийг **БҮРТГЭЛИЙН ХУРААМЖ ТӨЛСӨН ЗАРЧМЫН ДАГУУ** төлнө. Ингэснээр бүртгүүлэгч МУИС-д элсэх эрхээ баталгаажуулна.




### Баталгаажуулсан эрхээ цуцлах

Бүртгүүлэгч баталгаажуулсан эрхээ цуцлах боломжтой бөгөөд энэ тохиолдолд суурь хураамжийг буцаан олгохгүй. Мөн МУИС-д элсэх боломжгүй болно. Баталгаажуулсан эрхээ цуцлахын тулд харгалзах **Цуцлах** товч дээр дарна. **Цуцлах** товч дээр дарснаар дараах асуултыг бүртгүүлэгчээс лавлаж асуух бөгөөд хэрвээ цуцлахыг зөвшөөрч байвал харгалзах нүдийг сонгон гарч ирэх товч дээр даран баталгаажуулсан эрхээ цуцална.

#	Бүртгүүлсэн сургууль	Шалгалт (Оноо)	Үлдсэн Нийт хуваарийн тоо	Одоогоор эзэлсэн байр	Баталгаажуулах хугацаа	
1	ШИНЖЛЭХ УХААНЫ СУРГУУЛИЙН НИЙГМИЙН УХААНЫ САЛБАР	Математик, Англи хэл (605.4)	4 / 5	Сонгосон		Цуцлах

### Санамж:

- Бүртгүүлэгч тухайн салбар/сургуульд элсэх эрхээсээ татгалзах бол тухайн салбар/сургуульд элсэх боломжгүй болно.
- Хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч элсэх эрх олгох үйл ажиллагаа эхэлснээс хойш журамд заасан хугацааны дотор элсэх эрхээ баталгаажуулна. Хэрвээ журамд заасан хугацааны дотор элсэх эрхээ баталгаажуулаагүй тохиолдолд МУИС хариуцлага хүлээхгүй/. Энэ нөхцлөөр хяналтын тоонд багтсан бүртгүүлэгч элсэх эрхээ журамд заасан хугацааны дотор баталгаажуулах бөгөөд энэ хугацаанд элсэх эрхээ баталгаажуулаагүй бол мөн элсэх эрхээсээ татгалзсан гэж үзэж дараагийн бүртгүүлэгчид шилжинэ / заасан хугацаанд баталгаажуулаагүй тохиолдолд МУИС хариуцлага хүлээхгүй/.
- Бүртгүүлэгч хэд хэдэн салбар/сургуулийн хяналтын тоонд багтсан бол зөвхөн нэг салбар/сургуулийг сонгож элсэх эрхээ баталгаажуулна.
- Бүртгүүлэгч хяналтын тоонд багтсан салбар/сургуулиа баталгаажуулахын



тулд эхний улирлын суурь үйлчилгээний төлбөрийг заавал төлнө. Элсэх эрхээ баталгаажуулах хугацаандаа амжиж суурь үйлчилгээний төлбөрөө төлж чадаагүй бол элсэх эрхээсээ татгалзсан гэж үзнэ.

- Баталгаажуулсан эрхээ цуцалсан тохиолдолд ахин өөр салбар/сургууль сонгох боломжгүй болох бөгөөд МУИС-д элсэх эрхээсээ татгалзаж байна гэж үзнэ.
- Бүртгүүлэгч баталгаажуулсан эрхээ цуцалсан тохиолдолд суурь үйлчилгээний төлбөрийг буцаан олгохгүй.

### ЭЛСЭГЧ ТА

1. МУИС-д элсэн ороод эхний хичээлийн жилд ерөнхий суурийн 8 үндсэн чиглэл бүхий хичээлээс сонгон судална. Ерөнхий суурь хичээл нь оюутанд дээд боловсрол олгоход зайлшгүй шаардлагатай шинжлэх ухааны үндэс буюу ойлгомжтой ярих, бичих, тоон болон тоон бус мэдээллийг боловсруулах, олон ургальч үзэл баримтлалын учир шалтгааныг таньж мэдэх, багаар үр дүнтэй хамтарч ажиллах, хариуцлагатай байх, харилцан суралцах мэдлэг, ур чадварыг сонгон суралцах хэлбэрээр эзэмшүүлэх зорилготой бүлэг хичээл юм.

Ерөнхий суурь хичээлийн 8 чиглэл:

- Байгалийн ухаан
- Хүмүүнлэгийн ухаан
- Нийгмийн ухаан
- Иргэний боловсрол
- Судалгаа шинжилгээний арга зүй
- Яриа, бичгийн ур чадвар
- Англи хэл, бусад хэл
- Биеийн тамирын, эрүүл ахуй

2. МУИС-ийн ерөнхий суурийн хичээлээс сонгон судалсны дараа Мэргэжлийн хөтөлбөр сонгох журмын дагуу сурлагын голч дүн, амжилттай судалсан хичээлийн багц цаг, МУИС-д элсэхэд тооцуулсан элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоор жагсааж үндсэн мэргэжлээ сонгоно.

3. ШУС, ХШУИС-д элссэн оюутан тухайн сургуулиудын бүх хөтөлбөрөөс сонгон суралцах боломжтой. Мөн гүнзгийрүүлсэн сургалтат /honors program/ хөтөлбөрт хамрагдаж болно.

4. Үндсэн мэргэжлийнхээ сургалтын төлөвлөгөөн дэх ерөнхий суурь болон мэргэжлийн суурь хичээлийг бүрэн судалж, холбогдох шаардлагыг хангасан оюутан хос болон хавсарга мэргэжлээр суралцах боломжтой.

- Хос мэргэжлээр амжилттай суралцсан оюутанд давхар суралцсан мэргэжлийн хоёр дахь бакалаврын диплом олгоно.
- Хавсарга мэргэжил олгох хөтөлбөр нь оюутныг хөдөлмөрийн зах зээлд давуу боломжтой оролцох нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэх бөгөөд үндсэн мэргэжлээсээ гадна өөр сонирхсон мэргэжлийн хөтөлбөрөөс багц цаг судална.

### ХАЯГ БАЙРШИЛ, ХОЛБОО БАРИХ

Салбар/ нэгж	Хичээлийн байр/Өрөөний дугаар	Дотуур утасны дугаар	Yahoo messenger	Facebook хаяг	Веб сайт
Шинжлэх ухааны сургууль	МУИС-ийн хичээлийн II байр тоот	77307730-(2112), (2113), (2114), (2108), (2103), (2105)	sas.naturalscience@yahoo.com sas.socialscience@yahoo.com sas.humanitydivision@yahoo.com	МУИС Элсэлт	<a href="http://sas.num.edu.mn">http://sas.num.edu.mn</a>
Хэрэглээний шинжлэх ухаан, инженерчлэлийн сургууль	МУИС-ийн хичээлийн IIIa байр 212 тоот	77307730-(3104), (3103), (3108), (3106), (3107)	num_seas@yahoo.com	ХШУИС Сургалтын алба	<a href="http://seas.num.edu.mn">http://seas.num.edu.mn</a>
Бизнесийн сургууль	МУИС-ийн хичээлийн IV байр 203 тоот	77307730-(4104), (4106)	bs_muis@yahoo.com	МУИС-н BS-н elselt 2015	<a href="http://bs.num.edu.mn">http://bs.num.edu.mn</a>
Олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургууль	МУИС-ийн хичээлийн V байр 201 тоот	77307730-5103 77307730-5107	sirpa@yahoo.com	МУИС ОУХНУС	<a href="http://sirpa.num.edu.mn">http://sirpa.num.edu.mn</a>
Хууль зүйн сургууль	МУИС-ийн хичээлийн IIIb байр 206 тоот	773077360 (3501), (3503) 31-26-00	nergualtanzul@yahoo.com	Хууль зүйн сургууль хэс	<a href="http://law.num.edu.mn">http://law.num.edu.mn</a>
Орхон сургууль	Эрдэнэт хот дах салбар сургууль	Эрдэнэт хот дах салбар сургууль	muisorkhon@yahoo.com	МУИС-ийн Орхон сургууль	<a href="http://www.muis-orkhon.mn">http://www.muis-orkhon.mn</a>
Завхан сургууль	Завхан аймаг дах салбар сургууль	70462398, 70463949	num_zavkhan@yahoo.com	Num-Zavkhan	<a href="http://za.num.edu.mn">http://za.num.edu.mn</a>